



МОНГОЛ УЛСЫН
ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 259

Улаанбаатар хот


Төрийн хөрөнгөөр бүтээгдсэн кинонуудын
эзэмшигчийг тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн Төрийн өмчийн хорооноос ТОГТООХ нь:

1. Төрийн хөрөнгөөр бүтээсэн хавсралтад дурдсан уран сайхны болон баримтат киног эзэмших, ашиглах эрхийг “Монгол Кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газарт олгосугай.

2. Төрийн өмчийн кино бүтээлийг бусдад ашиглуулсанаас орсон орлогын 20 хувийг Төрийн өмчийн хорооны төрийн сангийн дансанд төвлөрүүлж, үлдэх хувийг тайлан балансад тухай бүр тусгаж байхыг “Монгол Кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газар /Ж.Солонго/-т үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналт шалгалтын газар /Б.Сүхбаатар/-т даалгасугай.



ДАРГА

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Д.СУГАР

Л.ГАНБАТ

Л.ГАНБАТ